

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны ...дугаар
сарын...-ны өдөр

Улаанбаатар хот

ЗӨРЧИЛ ШАЛГАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.Энэ хуулийн зорилт нь зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулахтай холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.

1.2 дугаар зүйл.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль тогтоомж

1.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Зөрчлийн тухай хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Хууль сахиулах ажиллагааны тухай хууль, энэ хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжоос бүрдэнэ.

1.3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ

1.Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль, эдгээртэй нийцүүлэн гаргасан бусад хууль, Монгол Улсын олон улсын гэрээг баримтална.

2.Энэ хууль нь Монгол Улсын нутаг дэвсгэрт хамаарах хилийн чанадад байгаа Дипломат төлөөлөгчийн газрын эзэмшил нутаг, усан, агаарын орон зайд байгаа Монгол Улсын усан онгоц, агаарын хөлөгт зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулахад нэгэн адил үйлчилнэ.

3.Монгол Улсын нутаг дэвсгэрт хүн, хуулийн этгээдэд холбогдуулан зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулахад энэ хууль, эдгээртэй харшлаагүй бусад хуулийн заалтыг зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд удирдлага болгоно.

4.Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны явцад хүн, хуулийн этгээдийн хуулиар хамгаалагдсан эрх, эрх чөлөөг дордуулсан хуулийг хэрэглэхгүй.

5.Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбоотой гаргасан журам, аргачилсан заавар нь энэ хуулийн зарчим, агуулгад нийцсэн байна.

1.4 дүгээр зүйл.Нэр томьёоны тодорхойлолт

1.Энэ хуульд хэрэглэсэн нэр томьёог дараахь утгаар ойлгоно:

1.1.“зөрчил шалган шийдвэрлэх” гэж зөрчлийн хэрэг бүртгэлт явуулах, түүнд тавих прокурорын хяналт, зөрчил шүүхээр хянан шийдвэрлэх ажиллагааг;

1.2.“оролцогч” гэж зөрчилд холбогдогч, хохирогч, тэдгээрийн хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчийг;

1.3.“хувийн баримт бичиг” гэж Монгол Улсын иргэний үнэмлэх, үндэсний гадаад паспорт, албаны болон жолоодох эрхийн үнэмлэх, гадаадын иргэний паспорт, эсхүл тэдгээртэй адилтгах баримт бичгийг;

1.4.“зөрчлийн хэрэг бүртгэлт” гэж эрх бүхий албан тушаалтан зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдийг тогтоох, шийтгэл оногдуулах эсэхийг шийдвэрлэх зорилгоор явуулах энэ хуульд заасан ажиллагааг;

1.5.“зөрчлийн хэрэг бүртгэлтийг удирдах албан тушаалтан” гэж эрх бүхий байгууллагын зөрчлийн хэрэг бүртгэлт хариуцсан удирдах албан тушаалтныг.

2.Энэ хуульд хэрэглэсэн бусад нэр томьёог Зөрчлийн тухай хууль, Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан утгаар ойлгоно.

1.5 дугаар зүйл.Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны хэл, бичиг

1.Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг монгол хэлээр явуулж, төрийн албан ёсны хэл, бичгээр хөтөлж, баримтжуулна.

2.Монгол хэл мэдэхгүй хүн өөрийн эх хэл болон мэдэх хэл, бичгээр, хөгжлийн бэрхшээлтэйн улмаас төрийн албан ёсны хэл, бичгээр харилцаж чадахгүй бол дохио зангаа, тусгай тэмдэгт ашиглан орчуулагч, хэлмэрчийн тусламж авах эрхээр хангагдана.

1.6 дугаар зүйл.Хугацаа тоолох

1.Энэ хуульд заасан хугацааг минут, цаг, хоног, сар, жилээр тоолно.

2.Хугацааг тоолж эхэлсэн минут, цаг, хоногийг хугацаа тоолоход оруулахгүй.

3.Хугацааг цагаар тоолоход уг хугацаа нь сүүлийн цаг, минутад дуусна.

4.Хугацааг хоногоор тоолоход уг хугацаа нь сүүлчийн хоногийн 24 цагт дуусна.

5.Хугацааг сараар тоолоход сүүлчийн сарын мөн өдөр уг хугацаа дуусна. Хэрэв энэ сард тохирох өдөр байхгүй бол мөн сарын эцсийн хоногт хугацаа дуусна.

6.Хугацааг жилээр тоолоход хугацаа нь дараа оны тухайн сарын тухайн өдөр дуусна. Хэрэв хугацааны төгсгөл ажлын бус өдөр тохиолдвол хугацааны сүүлийн өдрийг түүний дараагийн ажлын эхний өдрөөр тоолно.

7.Гомдол, бусад баримт бичгийг хугацаа дуусахын өмнө шууданд өгсөн бол хугацаа хэтэрсэнд тооцохгүй.

1.7 дугаар зүйл.Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны нууцлал

1.Шүүх, прокурор, эрх бүхий албан тушаалтан нь зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны явцад олж мэдсэн хувь хүн, байгууллага, төрийн нууцыг задруулахгүй байх, түүнийг хамгаалах арга хэмжээ авна.

2.Шүүх, прокурор, эрх бүхий албан тушаалтан нь хувь хүн, байгууллага, төрийн нууцтай холбоотой ажиллагаанд оролцсон, байлцсан хүнд нууцыг задруулахгүй байх үүргийг сануулж, бичгээр баталгаа гаргуулж авна.

1.8 дугаар зүйл.Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны харьяалал

1.Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг уг зөрчил гарсан нутаг дэвсгэр, энэ хуульд заасан харьяаллын дагуу явуулна.

2.Энэ хуульд заасан тохиолдолд зөрчлийн хэрэг бүртгэлтийг прокурорын зөвшөөрлөөр харьяалах нутаг дэвсгэрээс гадна явуулж болно.

3.Тухайн зөрчил хэд хэдэн нутаг дэвсгэрт үйлдэгдсэн бол сүүлчийн зөрчил үйлдэгдсэн нутаг дэвсгэрийн эрх бүхий байгууллага шалган шийдвэрлэнэ.

4.Зөрчил үйлдэгдсэн газрыг тогтоох боломжгүй, эрх бүхий албан тушаалтан хуулиар хүлээсэн чиг үүргээ хэд хэдэн аймаг, сум, дүүрэгт хэрэгжүүлэх явцад зөрчил илрүүлсэн, эсхүл оролцогч нь хэргийг харьяалах эрх бүхий албан тушаалтныг хувийн ашиг сонирхлын зөрчилтэй гэж үзэж, үндэслэл бүхий хүсэлт гаргасан бол зөрчлийн хэрэг бүртгэлтийн харьяаллыг прокурор тогтооно.

5.Эрх бүхий албан тушаалтан дараахь харьяаллын дагуу зөрчлийг шалган шийдвэрлэнэ:

5.1.хилийн төлөөлөгч, түүний орлогч, туслах Зөрчлийн тухай хуулийн 15.3 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 16.10 дугаар зүйлд заасан зөрчил;

5.2.төрийн тусгай хамгаалалтын газрын эрх бүхий албан тушаалтан Зөрчлийн тухай хуулийн 15.1 дүгээр зүйл, 15.3 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 15.11, 15.13 дугаар зүйлд заасан зөрчил;

5.3.аймаг, нийслэл, дүүргийн цэргийн штабын дарга Зөрчлийн тухай хуулийн 15.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 15.19 дүгээр зүйлд заасан зөрчил;

5.4.тагнуулын байгууллагын эрх бүхий ажилтан Зөрчлийн тухай хуулийн 7.8 дугаар зүйл, 15.3 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 15.9, 15.10 дугаар зүйлд заасан зөрчил;

5.5.олон нийтийн цагдаагийн ажилтан Зөрчлийн тухай хуулийн 5.1 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэг, 5.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 5.5 дугаар зүйл, 6.9 дүгээр зүйлийн 8.4 дэх заалт, 6.15 дугаар зүйлийн 8 дахь хэсэгт заасан зөрчил;

5.6.онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын эрх бүхий алба хаагч Зөрчлийн тухай хуулийн 5.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 5.16 дугаар зүйл, 15.12 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан зөрчил;

5.7.цагдаагийн байгууллагын эрх бүхий ажилтан Зөрчлийн тухай хуулийн 5.1 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэг, 5.3 дугаар зүйлийн 1, 3, 4 дэх заалт, 5.5 дугаар зүйлийн 1, 2, 4, 5 дахь хэсэг, 5.5 дугаар зүйлийн 11.4 дэх заалт, 5.5 дугаар зүйлийн 13, 14 дэх хэсэг, 5.7 дугаар зүйлийн 1.2, 1.4,1.5 дахь заалт, 5.7 дугаар зүйлийн 1.7 дахь хэсэг, 5.14 дүгээр зүйлийн 1.4, 1.5, 1.8 дахь заалт, 5.15дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 5.15 дугаар зүйлийн 2.1, 2.2 дахь заалт, 6.9 дүгээр зүйлийн 8.4 дэх заалт, 6.12 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, 6.15 дугаар зүйлийн 8 дахь хэсэг, 6.17 дугаар зүйлийн 7.5 дахь заалт, 7.1, 7.2, 7.3, 7.4, 7.5, 7.6, 7.7 дугаар зүйл, 7.8 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 7.10, 7.11 дүгээр зүйл, 8.2 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, 12.5 дугаар зүйл, 13.4 дүгээр зүйлийн 1, 2, 4 дэх хэсэг, 14.1, 14.2, 14.3, 14.4, 15.1, 15.2 дугаар зүйл, 15.3 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 15.4, 15.5, 15.6, 15.7, 15.8, 15.12, 15.14, 9.7, 9.8, 9.11, 9.24, 10.16, 15.27 дугаар зүйл, 15.28 лугаар зүйлийн 2 дахь хэсэг, 15.29, 15.30, 15.33, 16.1.2, 16.3, 16.4, 16.5, 16.6, 16.13, 16.15 дугаар зүйлд заасан зөрчил;

5.8.ахлах шийдвэр гүйцэтгэгч, ахлах тогтоол гүйцэтгэгч, хорих байгууллагын төлөөлөгч Зөрчлийн тухай хуулийн 15.3 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 7.10 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт заасан зөрчил;

5.9.мэргэжлийн хяналтын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 5.1, 5.2, 5.3, 5.4, 5.5 дугаар зүйл, 5.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 5.6 дугаар зүйлийн 3, 4, 5, 6, 6, 7, 8, 9 дэх хэсэг, 5.7, 5.8, 5.9, 5.10, 5.11, 5.12, 5.13, 5.14, 5.15, 5.16, 6.1, 6.2, 6.3, 6.4, 6.6, 6.7, 6.8, 6.9, 6.10, 6.11, 6.12, 6.13, 6.14, 6.15, 6.16, 6.17, 8.1, 8.2, 8.4, 9.5, 9.6, 9.7, 9.9, 9.12, 6.13, 9.15, 9.17, 9.18, 9.19, 9.20, 9.22, 10.2, 10.21, 11.1,11.2, 11.3, 11.4, 11.5, 11.6, 11.7, 11.8, 11.9, 12.1,12.2, 12.4, 12.5,12.7, 13.1, 13.2, 13.3 дугаар зүйл, 13.4 дүгээр зүйлийн 4, 5, 6 дахь хэсэг, 14.1, 14.2, 14.3 дугаар зүйл, 15.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 15.17, 15.18, 15.21, 15.22, 15.23, 15.24, 15.25 дугаар зүйл, 15.26 дугаар зүйлийн 2, 3, 4 дэх хэсэг, 15.26 дугаар зүйлийн 3, 4 дэх хэсэг,15.31 дугаар зүйл, 16.1 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, 16.5 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, 16.9, 16.12 дугаар зүйлд заасан зөрчил;

5.10.гаалийн улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 5.4. дүгннр зүйлийн 1.1, 2.8 дахь заалт, 5.5 дүгээр зүйлийн 9.1, 9.2, 9.3 дахь заалт, 5.5 дугаар зүйлийн 10 дахь хэсэг, 5.6 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 5.9 дугаар зүйлийн 5 дахь хэсэг, 5.12 дугаар зүйл, 5.14 дүгээр зүйл 1.1, 1.2 дахь заалт, 6.3 дугаар зүйл, 6.14 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, 7.4 дүгээр зүйлийн 9 дэх хэсэг, 7.9 дүгээр зүйлийн 4 дэх заалт, 9.6 дугаар зүйлийн 1.1 дэх заалт, 10.20 дугаар зүйл, 13.4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг,15.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчил;

5.11.татварын улсын байцаагч 6.5, 10.18, 10.23 дугаар зүйл, 15.3 дугаар зүйлийн1 дэх хэсэг, 16.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасан зөрчил;

5.12.гадаадын иргэний хяналтын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 9.16 дугаар зүйл, 15.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 16.12, 16.13 дугаар зүйлд заасан зөрчил;

5.13.оюуны өмчийн улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 5.3 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, 5.6 дугаар 7.3, 7.4, 7.5, 7.6, 7.7, 7.8, 7.9 дэх заалт, 5.9 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг, 5.15 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, 9.1, 9.2, 9.3, 9.4 дугаар зүйл, 13.4 дүгээр зүйлийн 1, 2 дугаар зүйл, 15.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчил;

5.14.шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газрын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 9.5, 9.10 дугаар зүйл, 15.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчил;

5.15.нийгмийн даатгалын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 10.24 дүгээр зүйл, 15.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 16.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасан зөрчил;

5.16.галын түймрийн хяналтын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 5.16 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 5.17 дугаар зүйл, 15.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 15.12 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан зөрчил;

5.17.санхүүгийн зохицуулах хорооны хянан шалгагч Зөрчлийн тухай хуулийн 7.9, 9.14, 10.2, 10.5, 10.6, 10.7, 10.8, 10.9, 10.11, 10.12, 10.13, 10.14, 10.15, 10.22, 10.25, 12.3, 12.6, 12.8 дугаар зүйл, 15.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчил;

5.18.монголбанкны хянан шалгагч Зөрчлийн тухай хуулийн 10.2, 10.3, 10.4, 10.7, 10.10, 10.14, 10.22 дугаар зүйл, 15.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчил;

5.19.улсын бүртгэлийн хяналтын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 8.3, 9.12, 9.13 дугаар зүйл, 15.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт, 15.28 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, 16.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, 16.13 дугаар зүйлд заасан зөрчил;

5.20.архив, албан хэрэг хөтлөлтийн хяналтын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 15.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 15.16 дугаар зүйл, 16.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасан зөрчил;

5.21.нягтлан бодох бүртгэлийн улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 9.23, 10.1, 10.17 дугаар зүйл, 15.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 15.26 дугаар зүйлийн 1, 5 дахь хэсэг, 15.28 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэгт заасан зөрчил;

5.22.статистикийн улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 15.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 16.7, 16.9 дугаар зүйлд заасан зөрчил;

5.23.нислэгийн аюулгүй ажиллагааны хяналт хариуцсан байцаагч Зөрчлийн тухай хуулийн 15.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 14.6, 14.7 дугаар зүйлд заасан зөрчил;

5.24.төмөр замын тээврийн улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 15.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 14.8 дугаар зүйлд заасан зөрчил;

5.25.хүүхдийн эрхийн ажилтан Зөрчлийн тухай хуулийн 7.10, 15.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 15.27 дугаар зүйлд заасан зөрчил;

5.26.улсын байцаагчийн эрхтэй байгаль хамгаалагч Зөрчлийн тухай хуулийн 5.1 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэг, 6.6 дугаар зүйлийн 1, 6 дахь хэсэг, 6.7 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэг, 6.8 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 9.12, 9.13 дугаар зүйл, 15.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчил.

6.Зөрчил шалган шийдвэрлэсэн эрх бүхий албан тушаалтан хүндээр өвдсөн, нас барсан, ажлаас халагдсан зэрэг бусад хүндэтгэн үзэх шалтгааны улмаас шүүх хуралдаанд оролцох боломжгүй бол зөрчлийн хэрэг бүртгэлтийг удирдах албан тушаалтны шийдвэрээр өөр албан тушаалтныг томилж болно.

7.Эрх бүхий албан тушаалтан хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэх явцад бусад эрх бүхий албан тушаалтны хуулиар харьяалуулан шалган шийдвэрлэх зөрчлийг илрүүлсэн бол тухайн эрх бүхий байгууллагад шилжүүлнэ.

1.9 дүгээр зүйл.Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулж болохгүй тохиолдол

1.Дараахь тохиолдолд зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулж болохгүй:

1.1.зөрчлийн шинжгүй;

1.2.Зөрчлийн тухай хуульд заасан хөөн хэлэлцэх хугацаа өнгөрсөн;

1.3.тухайн зөрчилд хариуцлага тооцсон хуулийн зүйл, хэсэг, заалт хүчингүй болсон;

1.4.зөрчил үйлдсэн хүн нас барсан;

1.5.тухайн зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд шийтгэл оногдуулсан эрх бүхий албан тушаалтан, шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр бол.

1.10 дугаар зүйл.Хэтэрсэн хугацааг сэргээх

1.Оролцогч хугацаа сэргээлгэх тухай үндэслэл бүхий хүсэлт гаргавал зөрчлийн хэрэг бүртгэлтийг удирдах албан тушаалтан хэтэрсэн хугацааг сэргээх шийдвэр гаргаж болно.

2.Зөрчлийн хэрэг бүртгэлтийг удирдах албан тушаалтан нь оролцогчийн хүсэлтээр хэтэрсэн хугацааг сэргээх асуудлыг шийдвэрлэх хүртэл тухайн хугацаанаас хамааралтай гарсан шийдвэрийг биелүүлэхийг түдгэлзүүлж болно.

3.Энэ зүйлд заасан хэтэрсэн хугацааг сэргээх нь энэ хуулийн 6.7 дугаар зүйлд заасан хугацаанд хамаарахгүй.

1.11 дүгээр зүйл.Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны зардал

1.Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны зардалд дараахь зардал хамаарна:

1.1.гэрч, хөндлөнгийн гэрч, шинжээч, орчуулагч, хэлмэрчид төлөх зардал, урамшуулал;

1.2.эд мөрийн баримтыг хадгалах, шилжүүлэх, устгахад гарах зардал;

1.3.тухайн зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаатай шууд холбогдон гарах бусад зардал;

1.4.хохирол, хор уршгийн үнэлгээ хийх, шинжилгээ хийлгэхтэй холбоотой зардал.

2.Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны зардалд прокурор, шүүхийн зардлыг оруулж тооцно.

3.Энэ зүйлийн 1, 2 дахь хэсэгт заасан ажиллагааны зардал, тооцох журмыг Засгийн газар батална.

4.Шүүх, прокурор, эрх бүхий албан тушлаатан энэ зүйлийн 1, 2 дахь хэсэгт заасан зардлыг зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдээр нөхөн төлүүлнэ.

5.Албан үүргийн хувиар оролцсон шинжээч, мэргэжилтэн, хэлмэрч, орчуулагчид энэ зүйлд заасан урамшуулал олгохгүй.

1.12 дугаар зүйл.Эрх бүхий албан тушаалтны шийдвэр, үйл ажиллагаанд гомдол гаргах

1.Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны явцад оролцогч нь эрх бүхий албан тушаалтны шийдвэр, үйл ажиллагааны талаархи гомдлоо тухайн зөрчлийн хэрэг бүртгэлтийг удирдах албан тушаалтанд гаргаж болно.

2.Энэ зүйлд заасан зөрчлийн хэрэг бүртгэлтийг удирдах албан тушаалтны шийдвэрийг хүлээн зөвшөөрөхгүй бол шийдвэрийг хүлээн авснаас хойш ажлын 5 өдрийн дотор прокурорт гомдол гаргаж болно.

3.Энэ зүйлийн 1, 2 дахь хэсэгт заасан гомдлыг эрх бүхий албан тушаалтан, прокурор хүлээн авснаас хойш ажлын 5 өдрийн дотор хянан шийдвэрлэнэ.

4.Гомдлыг хянан шийдвэрлэх ажиллагаанд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн Арван дөрөвдүгээр бүлэгт заасан журмыг баримтална.

1.13 дугаар зүйл.Хүсэлт гаргах

1.Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны явцад оролцогч нь тодорхой ажиллагаа явуулах тухай хүсэлтийг эрх бүхий албан тушаалтан, зөрчлийн хэрэг бүртгэлтийг удирдах албан тушаалтанд гаргаж болно.

2.Эрх бүхий албан тушаалтан, зөрчлийн хэрэг бүртгэлтийг удирдах албан тушаалтан энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан хүсэлтийг хангах үндэслэл тодорхой бол даруй, шалгах шаардлагатай тохиолдолд түүнийг гаргаснаас хойш ажлын 3 өдрийн дотор хангах эсэхийг шийдвэрлэнэ.

3.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан хүсэлтийг шийдвэрлэхэд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн Арван дөрөвдүгээр бүлэгт заасан журмыг баримтлана.

**ХОЁРДУГААР БҮЛЭГ
ЗӨРЧЛИЙН ХЭРЭГ ШАЛГАН ШИЙДВЭРЛЭХ
АЖИЛЛАГААГ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ**

2.1 дүгээр зүйл.Зөрчил хянан шийдвэрлэх шүүх

1.Эрүүгийн хэргийн шүүх Зөрчлийн тухай хуульд заасан зөрчлийг хуульд заасан харьяаллын дагуу анхан, давж заалдах журмаар хянан шийдвэрлэнэ.

2.2 дугаар зүйл.Прокурор

1.Прокурор зөрчлийн хэрэг бүртгэлтэд хяналт тавих дараахь бүрэн эрхтэй:

1.1.зөрчлийн шинжтэй гомдол, мэдээллийг хүлээн авах, бүртгэх ажиллагаа хуулийн хүрээнд явагдаж байгаа эсэхийг хянах;

1.2.зөрчлийг өөрөө илрүүлсэн, мэдээлэл хүлээн авсан бол харьяаллын дагуу шилжүүлэх;

1.3.энэ хуульд заасны дагуу оролцогчийн гаргасан гомдол, бусад үндэслэлээр зөрчлийн хэргийг хянах;

1.4.прокурорын хяналтын явцад илэрсэн зөрчлийг арилгуулах талаар эрх бүхий байгууллагад шаардлага хүргүүлэх;

1.5.энэ хуульд заасан прокурорын зөвшөөрлөөр явуулах ажиллагааны зөвшөөрөл олгох, тодорхой ажиллагаа гүйцэтгүүлэхээр даалгавар өгөх;

1.6.эрх бүхий албан тцшаалтны эрх хязгаарлах арга хэмжээ хэрэгжүүлэхтэй холбоотой гаргасан саналыг шийдвэрлэх;

1.7.үйлдэл, эс үйлдэхүй нь гэмт хэргийн шинжтэй бол хэрэг бүртгэлтийн хэрэг нээх, эсхүл эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татаж, харьяаллын дагуу шилжүүлэх;

1.8.хуульд заасан бусад эрх.

2.Прокурор зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны явцад эрх бүхий албан тушаалтны хүн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд хууль бусаар халдсан үйлдлийг мэдсэн даруй таслан зогсоох арга хэмжээ авна.

3.Зөрчлийн хэрэг бүртгэлтийн явцад гаргасан прокурорын шийдвэрийг эрх бүхий албан тушаалтан нь эс зөвшөөрвөл шийдвэрийг гарснаас хойш ажлын 3 өдрийн дотор тухайн прокурорын газрын дээд шатны прокурорт нэг удаа гомдол гаргана.

4.Гомдлыг хүлээн авсан прокурор ажлын 5 өдрийн дотор хянан шийдвэрлэнэ.

5.Прокурор энэ зүйлд заасан гомдлыг шийдвэрлэхэд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн Арван дөрөвдүгээр бүлэгт заасан нийтлэг журмыг баримтална.

2.3 дугаар дугаар зүйл.Зөрчлийн хэрэг бүртгэлтийг удирдах албан тушаалтан

1.Зөрчлийн хэрэг бүртгэлтийг удирдах албан тушаалтан дараахь эрхтэй:

1.1.зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг зохион байгуулалт, мэргэжлийн удирдлагаар хангах;

1.2.зөрчлийн хэрэг бүртгэлт явуулах үүргийг нэг, эсхүл хэд хэдэн эрх бүхий албан тушаалтанд даалгах;

1.3.шаардлагатай бол зөрчлийн хэргийг өөр эрх бүхий албан тушаалтанд шилжүүлэх;

1.4.эрх бүхий албан тушаалтны үйл ажиллагаатай холбоотой гомдлыг хянан шийдвэрлэх;

1.5.зөрчлийн хэрэг бүртгэлтийн хэргийг харьяаллын дагуу шилжүүлэхээр прокурорт танилцуулж, шийдвэрлүүлэх;

1.6.шаардлагатай бол эрх бүхий албан тушаалтны бүрэн эрхийг хэрэгжүүлэх.

2.4 дүгээр зүйл. Эрх бүхий албан тушаалтан

1.Хуулиар хүлээлгэсэн чиг үүргийн хүрээнд энэ хуулийн 1.8 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт заасан эрх бүхий албан тушаалтан зөрчил хянан шийдвэрлэх ажиллагааны явцад дараахь бүрэн эрхтэй:

1.1.хуулиар харъяаллуулсан зөрчлийг өөрөө илрүүлсэн эсхүл зөрчлийн тухай гомдол, мэдээлэл ирүүлснийг хүлээн авч хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэх;

1.2.зөрчлийн шинжтэй гомдол, мэдээллийг хүлээн авах, бүртгэх;

1.3.хуульд заасан үндэслэл, журмын дагуу зөрчлийн гомдол, мэдээллийг хүлээн авахаас татгалзах, зөрчлийн хэрэг нээх, хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэх;

1.4.зөрчлийн тухай гомдол, мэдээллийг харъяаллын дагуу шилжүүлэх саналыг прокурорт гаргах;

1.5.зөрчлийн хэрэг бүртгэлтийн ажиллагааг хуульд заасан үндэслэл, журмын дагуу явуулах;

1.6.прокурорын шийдвэр, үйл ажиллагааны талаар хуульд заасан журмын дагуу тухайн прокурорын газрын дээд шатны прокурорт гомдол гаргах;

1.7.зөрчил хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогчийн хүсэлтийг хуульд заасан үндэслэл, журмын дагуу шийдвэрлэх;

1.8.хуульд үндэслэл, журмын дагуу эрх хязгаарлах арга хэмжээг хэрэглэх;

1.9.хуулиар харъяаллуулсан зөрчилд шийтгэл оногдуулах, хуульд тусгайлан заасан тохиолдолд зөрчлийн үр дагаврыг арилгуулах арга хэмжээ авах эсхүл албадлагын арга хэмжээ хэрэглэх саналыг шүүхэд гаргах;

1.10.зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээд тогтоосон хугацаанд шийтгэлийг биелүүлээгүй бол албадан гүйцэтгүүлэхээр шүүхэд хүсэлт гаргах, шүүх хуралдаанд оролцох;

1.11. хуульд заасан бусад эрх.

ГУРАВДУГААР БҮЛЭГ ЗӨРЧЛИЙН ХЭРЭГ ШАЛГАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААНЫ ОРОЛЦОГЧ

3.1 дүгээр зүйл.Холбогдогч

1.Эрх бүхий албан тушаалтан нь зөрчил үйлдсэн гэж буруутгагдаж байгаа хүн, хуулийн этгээдийг холбогдогчоор тогтооно.

2.Холбогдогч дараахь эрхтэй:

2.1.хууль зүйн туслалцаа авах;

2.2.эрх бүхий албан тушаалтан, прокурорын үйл ажиллагаа, шийдвэр, шүүхийн шийдвэрт гомдол гаргах;

2.3.зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд биеэр оролцох;

2.4.зөрчлийн хэрэг бүртгэлт дууссаны дараа нотлох баримттай танилцах;

2.5.зөрчлийн талаар мэдүүлэг өгөх, нотлох баримт гаргаж өгөх;

2.6.нотлох баримт шалгуулах тухай хүсэлт гаргах;

3.Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд хуулийн этгээдийг дараахь хүнээр төлөөлүүлж болохгүй:

3.1.хуулийн этгээдийн эсрэг мэдүүлэг өгч байгаа бол;

3.2.хуулийн этгээдийг төлөөлөх хүн нь тухайн зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд холбогдогчоор оролцож байгаа бол.

4.Холбогдогчоос өөр тухайн хуулийн этгээдийг төлөөлөх хүн байхгүй тохиолдолд энэ зүйлийн 3 дахь хэсэгт заасан хамаарахгүй.

5.Энэ зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу хуулийн этгээдийг төлөөлөх хүн байхгүй бол 72 цагийн дотор өөр этгээдийг хууль ёсны төлөөлөгчөөр томилохыг эрх бүхий албан тушаалтан хуулийн этгээдэд бичгээр мэдэгдэнэ.

6.Хуулийн этгээд нь тогтоосон хугацаанд хууль ёсны төлөөлөгчөө томилоогүй бол эрх бүхий албан тушаалтан, прокурор, шүүхээс хууль ёсны төлөөлөгчийг томилж болно.

7.Прокурор нь эрх бүхий албан тушаалтны саналыг үндэслэн зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа дуусах хүртэл хуулийн этгээдийг татан буулгахгүй, улсын бүртгэлийн жагсаалтын мэдээлэлд өөрчлөлт оруулахгүй байх, түүнийг цуцлах талаар зохих байгууллагад даалгаж болно.

3.2 дугаар зүйл. Хохирогч

1.Зөрчлийн улмаас эрх, хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдсөн хүн, хуулийн этгээдийг хохирогч гэнэ.

2.Хохирогч дараахь эрхтэй:

2.1.хууль зүйн туслалцаа авах;
2.2.баримт гаргаж өгөх;
2.3.нотлох баримт шалгуулах хүсэлт гаргах;
2.4.эрх бүхий албан тушаалтан, прокурорын үйл ажиллагаа, шийдвэр, шүүхийн шийдвэрт гомдол гаргах;

2.5.эх хэлээрээ, эсхүл сайн мэдэх хэлээрээ мэдүүлэг өгөх, орчуулагч, хэлмэрч авах;

2.6.шүүхийн шийдвэрт гаргасан холбогдогчийн гомдолтой танилцаж тайлбар гаргах;

2.8.зөрчлийн улмаас өөрт учирсан хохирол, хор уршгийг нэхэмжлэх, нөхөн төлүүлэх хүсэлт гаргах;

2.9.хуульд заасан бусад эрх.

3.Хохирогч энэ хуульд заасан эрхээ хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчөөр дамжуулан хэрэгжүүлж болно.

3.3 дугаар зүйл.Өмгөөлөгч

1.Холбогдогч, хохирогчийн хүсэлтийг үндэслэн зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд өмгөөлөгч оролцож болно.

2.Холбогдогч, хохирогч зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны аль ч үед өмгөөлөгч авч болно.

3.Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны өмгөөлөгчийн оролцоо нь хууль зүйн туслалцаа авч байгаа талын хүсэлтээр тодорхойлогдоно.

4.Өмгөөлөгч нь зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд оролцохдоо Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн¹ 38 дугаар зүйлд заасан үүрэг хүлээнэ.

1 Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2012 оны 11 дугаарт нийтлэгдсэн.

3.4 дүгээр зүйл.Орчуулагч, хэлмэрч

1.Эрх бүхий албан тушаалтан, прокурор, шүүх нь монгол хэл мэдэхгүй, эсхүл хөгжлийн бэрхшээлтэйн улмаас төрийн албан ёсны хэл, бичгээр харилцаж чадахгүй оролцогчийг орчуулагч, хэлмэрчийн тусламж авах боломжоор хангах үүрэгтэй.

2.Эрх бүхий албан тушаалтан, прокурор, шүүх нь орчуулга хийх, хэлмэрчлэх мэдлэг, чадвартай хүнийг орчуулагч, хэлмэрчээр оролцуулж болно.

3.Орчуулагч, хэлмэрч дараахь эрхтэй:

3.1.өөрийн оролцсон зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны тэмдэглэлтэй танилцаж, засвар оруулах хүсэлт гаргах;

3.2.орчуулах, хэлмэрчлэх мэдлэг, чадвар хүрэхгүй бол оролцохоос татгалзах;

4.Орчуулагч, хэлмэрч дараахь үүрэгтэй:

4.1.эрх бүхий албан тушаалтан, прокурор, шүүхийн дуудсан цагт ирж орчуулах, хэлмэрчлэх;

4.2.үнэн зөв орчуулах, хэлмэрчлэх;

4.3.үнэн зөв орчуулсан, хэлмэрчилснээ баталж баримт бичиг, эсхүл өөрийн оролцоотой явагдсан зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны тэмдэглэлд гарын үсэг зурах;

4.4.хэлмэрчлэх, орчуулах явцад мэдсэн төр, байгууллага, хувь хүний нууц, хэргийн талаар задруулахгүй байх;

5.Энэ хуульд заасан журам нь сонсгол, хэл, ярианы бэрхшээлтэй хүний дохио, зангаа, тусгай тэмдэгтийг хэлмэрчлэхэд нэгэн адил хамаарна.

6.Эрх бүхий албан тушаалтан хойшлуулшгүй тохиолдолд, эсхүл хялбаршуулсан журмаар зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны явцад хэлмэрч, орчуулагчийг оролцуулахгүй байж болно.

3.5 дугаар зүйл.Хууль ёсны төлөөлөгч

1.Эрх бүхий албан тушаалтан дараахь хүнийг хууль ёсны төлөөлөгчөөр тогтооно:

1.1.арван найман насанд хүрээгүй холбогдогчийн эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийг;

1.2.хуулийн этгээдийн эрх бүхий албан тушаалтан, эсхүл итгэмжлэгдсэн төлөөлөгчийг.

2.Хууль ёсны төлөөлөгчийг тогтоохтой холбоотой хүсэлт, гомдлыг зөрчлийн хэрэг бүртгэлтийг удирдах албан тушаалтан, эсхүл прокурор шийдвэрлэнэ.

3.Хууль ёсны төлөөлөгч нь зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны явцад төлөөлж байгаа оролцогчийн эрхийг эдэлж, үүргийг хүлээнэ.

3.6 дугаар зүйл.Гэрч

1.Зөрчил шалган шийдвэрлэхэд ач холбогдол бүхий нөхцөл байдлын талаар мэдээлэл өгч байгаа хүнийг гэрч гэнэ.

2.Гэрч нь зөрчлийн хэргийн талаар өөрийн мэдэх зүйлийг үнэн зөв мэдүүлнэ.

3.Гэрч өөрийн болон гэр бүлийн гишүүн, эцэг, эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх эрхтэй.

3.7 дугаар зүйл.Хөндлөнгийн гэрч

1.Эрх бүхий албан тушаалтан шаардлагатай бол зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны явц, үр дүнг баталгаажуулахаар тухайн ажиллагаанд хөндлөнгийн гэрчийг оролцуулж болно.

2.Хөндлөнгийн гэрч нь тухайн хэрэгт хувийн сонирхолгүй хоёроос доошгүй хүн байна.

3.Хөндлөнгийн гэрч нь өөрийн оролцсон зөрчил шалгах ажиллагааны талаар гомдол гаргах, ажиллагааны тэмдэглэлтэй танилцах, түүнд засвар оруулах тухай хүсэлт гаргаж болно.

4.Хөндлөнгийн гэрч нь зөрчил шалгах ажиллагааны журмыг сахиж, нууцыг задруулахгүй байх үүрэг хүлээнэ.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ ЗӨРЧИЛ ШАЛГАХ АЖИЛЛАГАА ЯВУУЛАХ ЖУРАМ

4.1 дүгээр зүйл.Зөрчил шалгах ажиллагаа

1.Эрх бүхий албан тушаалтан энэ хуульд заасны дагуу зөрчил шалгах ажиллагаа явуулж, нотлох баримт цуглуулж, бэхжүүлнэ.

2.Зөрчил шалгах ажиллагаа нь зөрчил үйлдэгдсэн газар, хүн, хуулийн этгээдийн эзэмшил газар, барилга байгууламж, тээврийн хэрэгсэл, хүний бие, эд зүйлд үзлэг хийх, хүн, хуулийн этгээдийн баримт бичгийг шалгах, баримт бичиг, мэдээлэл гаргуулан авах, эд зүйл, баримт бичгийг хураан авах, эд хөрөнгийг битүүмжлэх, эд хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах, мэдүүлэг авах, шинжилгээнд зориулж хэв загвар, дээж авах, шинжилгээ хийлгэх ажиллагаанаас бүрдэнэ.

3.Эрх бүхий албан тушаалтан нь энэ хуульд прокурорын зөвшөөрлөөр явуулахаар зааснаас бусад ажиллагааг явуулах шийдвэрийг бие даан гаргана.

4.Эрх бүхий албан тушаалтан нь зөрчил шалгах ажиллагааны явцад гэмт хэргийн шинж тогтоогдвол даруй прокурорт мэдэгдэж, холбогдох баримтыг хүргүүлнэ.

5.Эрх бүхий албан тушаалтан нь зөрчил шалгах ажиллагаанд бусад хуулиар өөрт нь олгогдсон эрхийн хүрээнд хяналт шалгалтын журмыг хэрэглэхдээ энэ хуулийн 1.3 дугаар зүйлд заасныг баримтална.

6.Энэ бүлэгт заасан зөрчил шалгах ажиллагааны тэмдэглэл, шийдвэрийн загвар, журмыг Улсын ерөнхий прокурор батална.

4.2 дугаар зүйл.Прокуророос зөвшөөрөл авах ажиллагаа

1.Эрх бүхий албан тушаалтан энэ хуульд заасан прокурорын зөвшөөрлөөр явуулах ажиллагааны саналыг 24 цагаас доошгүй хугацааны өмнө прокурорт хүргүүлнэ.

2.Эрх бүхий албан тушаалтан энэ хуульд заасан прокурорын зөвшөөрлөөр явуулах ажиллагааны зөвшөөрлийг авахдаа Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 21.2, 21.3 дугаар зүйлд заасан журмыг баримтална.

3.Хойшлуулшгүй тохиолдолд тухайн ажиллагааг прокурорын зөвшөөрөлгүй явуулсан бол хүчинтэйд тооцох эсэхийг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 21.4 дүгээр зүйлд заасан журмын дагуу шийдвэрлэнэ.

4.3 дугаар зүйл.Үзлэг хийх

1.Эрх бүхий албан тушаалтан зөрчил үйлдэгдсэн даруй өөрийн санаачилгаар, зөрчил шалган шийдвэрлэхэд ач холбогдол бүхий нотлох баримтыг тогтоох зорилгоор прокурорын зөвшөөрлөөр зөрчил үйлдэгдсэн газар, тээврийн хэрэгсэл, хүний бие, бусад зүйлд үзлэг хийж болно.

2.Хүний биед хийх үзлэгийг энэ хуулийн 1.8 дугаар зүйлийн 5.1, 5.2, 5.7-д заасан эрх бүхий албан тушаалтан хийнэ.

3.Үзлэг хийхдээ байгаа зүйлийг тухайн хүний сайн дурын үндсэн дээр гаргуулан авч, эсхүл гадна талаас нь харах, гараар тэмтрэх, тусгай багаж ашиглах аргаар хийж болно.

4.Хүний биед үзлэг хийхэд өмссөн хувцас, биедээ авч яваа эд зүйлийг хамтад нь үзнэ.

5.Үзлэгийг тухайн нөхцөлд тохирсон хамгийн богино хугацаанд хийнэ.

6.Үзлэг хийхэд удаан хугацаа шаардагдах, эсхүл бусад үндэслэл байвал эрх бүхий байгууллага дээр хийж болно.

7.Хүний биед гараар тэмтэрч үзлэг хийхэд ижил хүйсийн албан тушаалтан хийнэ. Шаардлагатай бол хүний эмч, сувилагчийг оролцуулж болно.

8.Эд зүйл, баримт бичиг, ачаа тээш, мал, амьтан, тээврийн хэрэгсэлд үзлэг хийхэд эзэмшигчийг байлцуулна. Эзэмшигчийг оролцуулах боломжгүй бол хөндлөнгийн гэрчийг байлцуулж, эсхүл дуу-дүрсний бичлэгээр бэхжүүлнэ.

9.Үзлэг хийх үед хуулиар хориглосон зүйл илэрвэл хураан авна.

10.Үзлэг хийх ажиллагааны үед шаардлагатай бол хэв загвар, дээж авах, битүүмжлэх, хураан авах ажиллагааг явуулж болно.

4.4 дүгээр зүйл.Нотлох баримт

1.Зөрчил шалган шийдвэрлэхэд ач холбогдол бүхий хуульд заасан үндэслэл, журмын дагуу олж авсан аливаа баримтат мэдээллийг нотлох баримт гэнэ.

2.Зөрчлийн нотлох баримт нь гэрч, хохирогч, холбогдогчийн мэдүүлэг, бичмэл ба эд мөрийн баримт, эсхүл баримт бичиг, шинжээчийн дүгнэлт, мэдүүлэг, кино ба гэрэл зураг, зураглал, дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэг, хэв загвар, дээж, зөрчил шалгах ажиллагааны болон шүүх хуралдааны тэмдэглэл, хүн, хуулийн этгээд, албан тушаалтнаас ирүүлсэн зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл болон бусад баримтаар тодорхойлогдоно.

3.Нотлох баримтыг хууль бус арга, хэрэгслээр цуглуулж, бэхжүүлэхийг хориглоно.

4.Хууль сахиулах ажиллагааны тухай хуулийн 1.10 дугаар зүйлд заасан төхөөрөмжөөр бэхжүүлсэн дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэг, 2.14 дүгээр зүйлд заасан тэмдэглэлийг нотлох баримтад тооцно.

4.5 дугаар зүйл.Зөрчлийг нотлох

1.Эрх бүхий албан тушаалтан гаргасан шийдвэрийнхээ үндэслэлийг нотлох үүрэг хүлээнэ.

2.Эрх бүхий албан тушаалтан, прокурор нь хүн, хуулийн этгээдээс нотлох баримтыг гаргуулан авч болно.

3.Хуульд заасан журмыг зөрчиж цуглуулсан, бэхжүүлсэн нотлох баримт нотлох чадвараа алдах бөгөөд энэ хуульд заасан шийдвэрийн үндэслэл болохгүй.

4.Хүн, хуулийн этгээдийн гаргаж өгсөн эх бичмэл нотлох баримтыг тухайн хэргийн талаар гаргасан шийдвэр хүчин төгөлдөр болсны дараа буцаан өгч хуулбарыг хэрэгт хавсаргаж болно.

4.6 дугаар зүйл.Мэдээлэл, баримт бичиг гаргуулан авах

1.Эрх бүхий албан тушаалтан байгууллага, хувь хүний нууцтай холбоотой мэдээлэл, баримт бичгийг холбогдох байгууллага, албан тушаалтан, хүнээс прокурорын зөвшөөрлөөр гаргуулан авна.

2.Эрх бүхий албан тушаалтан энэ зүйлийн 1 дэх хэсэгт зааснаас бусад мэдээлэл, баримт бичгийг байгууллага, албан тушаалтнаас гаргуулан авч болно.

3.Энэ зүйлийн 1, 2 дахь хэсэгт заасан байгууллага, албан тушаалтан, хүн нь прокурорын шийдвэр, эрх бүхий албан тушаалтны даалгаварт заасан хугацаа, хэлбэрийн дагуу мэдээлэл, баримт бичгийг гарган өгч, нууцлалыг хадгална.

4.7 дугаар зүйл.Эд зүйл, баримт бичиг хураан авах

1.Эрх бүхий албан тушаалтан Зөрчлийн тухай хуульд заасан албадлагын арга хэмжээг хангах зорилгоор зөрчил үйлдэж олсон хөрөнгө, орлого, эд зүйл, зөрчил үйлдэхэд ашигласан зэвсэг, хэрэгсэл, тээврийн хэрэгсэл, уналга, эсхүл зөрчил шалгах ажиллагаанд ач холбогдолтой эд зүйл, баримт бичгийг прокурорын зөвшөөрлөөр хураан авна.

2.Эд зүйл, баримт бичиг хураан авах бол Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 23.4 дүгээр зүйлд заасан журмыг баримтална.

4.8 дугаар зүйл.Эд хөрөнгө битүүмжлэх

1.Эрх бүхий албан тушаалтан хураан авах эд хөрөнгө нь овор хэмжээ, эсхүл бусад шалтгаанаар зөрчлийн хэргийн баримтад хадгалах боломжгүй бол байгаа газарт нь прокурорын зөвшөөрлөөр битүүмжилнэ.

2.Эд хөрөнгийг битүүмжлэхдээ тухайн хүнд эд хөрөнгийг бусдад шилжүүлэх, устгах, өөрчлөх, захиран зарцуулах, хөдөлгөхийг хориглож, өөрт нь, эсхүл бусад боломжтой хүнд хадгалах, хамгаалах үүрэг хүлээлгэнэ.

3.Эрх бүхий албан тушаалтан энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу хадгалах, хамгаалах үүрэг хүлээсэн хүнд эд хөрөнгийг хүлээлгэн өгч, хуульд заасан хариуцлагыг сануулж гарын үсэг зуруулна.

4.Эд хөрөнгө битүүмжлэх ажиллагааг хураан авах, үзлэг хийх ажиллагаатай хамтатган явуулж болно.

5.Эд хөрөнгө битүүмжлэх ажиллагаанд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 20.2 дугаар зүйлд заасан журмыг баримтална.

4.9 дүгээр зүйл.Хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах

1.Эрх бүхий албан тушаалтан зөрчил үйлдэхэд ашигласан, үйлдэж олсон байж болох, эсхүл зөрчил шалган шийдвэрлэхэд ач холбогдолтой эд хөрөнгийг нуух, устгах, эрх шилжүүлэх үндэслэл бүхий сэжиг байвал прокурорын зөвшөөрлөөр үл хөдлөх болон эдийн бус хөрөнгө, санхүүгийн хэрэгсэл, зохиогчийн эрх, патент, гэрчилгээ, лиценз, тусгай зөвшөөрөл, тээврийн хэрэгслийн бүртгэл, банк болон бусад санхүүгийн байгууллагад байгаа мөнгөн хөрөнгийн гүйлгээний шилжилт хөдөлгөөнийг хязгаарлахыг зохих байгууллагад даалгана.

4.10 дугаар зүйл.Мэдүүлэг авах

1.Эрх бүхий албан тушаалтан зөрчил гарсан байдлыг тодруулах, зөрчил шалган шийдвэрлэхэд ач холбогдол бүхий баримт, мэдээллийг олох зорилгоор мэдүүлэг авна.

2.Мэдүүлгийг тухайн хүнийг эрх бүхий байгууллагад ирүүлэн, эсхүл тухайн хүний байгаа газарт авч болно.

3.Холбогдогчоос мэдүүлэг авахын өмнө тухайн хүнд үнэн зөв мэдүүлэг өгөхийн ач холбогдлыг тайлбарлаж, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаатай холбоотой нууцлалыг хадгалах талаар мэдэгдэнэ.

4.Эрх бүхий албан тушаалтан хүнийг албадан ирүүлэх, үнэн зөв мэдүүлэг өгөхийг шаардах эрхгүй.

5.Тухайн хүн хүсвэл мэдүүлгийг бичгээр өгч болно.

6.Эрх бүхий албан тушаалтан мэдүүлгийг асуулт асууж, хариулт авах хэлбэрээр явуулна.

7.Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар, эсхүл хүний нэр төрийг гутаан доромжлон харьцаж мэдүүлэгаахыг хориглоно.

8.Мэдүүлэг өгч байгаа хүн тоо болон санахад төвөгтэй бусад зүйлийн талаар мэдүүлэг өгөх бол эрх бүхий албан тушаалтны зөвшөөрснөөр баримт бичиг, бичлэг ашиглаж болно. Ашигласан баримт бичиг, бичлэгийн тухай тэмдэглэлд тусгаж, боломжтой бол хавсаргана.

9.Мэдүүлэг өгч байгаа хүнд эд мөрийн баримтыг үзүүлэх, бусад хүнээс өгсөн мэдүүлгийг танилцуулж, энэ талаар мэдүүлэг авч болно.

10.Мэдүүлэг авах ажиллагааг 3 цагаас илүү хугацаагаар явуулах бол 30 минутын завсарлага олгоно. Нэг удаагийн мэдүүлэг авах ажиллагаа нийт 6 цагаас хэтэрч болохгүй.

11.Мэдүүлэг авч дуусмагц тэмдэглэлийг мэдүүлэг өгч байгаа хүнд танилцуулж, нэмэлт оруулах, засвар хийх боломж олгоно.

12.Мэдүүлэг өгөхөөс татгалзсан бол энэ талаар тэмдэглэлд тусгана.

13.Доор дурдсанаас бусад тохиолдолд мэдүүлгийг шөнийн цагаар авахыг хориглоно:

13.1.шөнийн цагаар явагдаж байгаа үйлдвэрлэл, ажил, үйлчилгээний газарт гарсан зөрчлийг газар дээр нь шийдвэрлэхээр бол;

13.2.олон нийтийн аюулгүй байдал, хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд аюул учирч болох нөхцөл байдал үүссэн, эсхүл үүсч болзошгүй бол;

13.3.зөрчлийн ул мөр устгах, холбогдогч оргон зайлж болзошгүй бол;

13.4.гудамж, талбай, олон нийтийн газарт шөнийн цагаар үйлдэгдсэн зөрчлийг хялбаршуулсан журмаар болон газар дээр нь шалган шийдвэрлэх бол.

14.Эрх бүхий албан тушаалтан мэдүүлгийг тэмдэглэлээр бэхжүүлж, мэдүүлэг өгсөн хүн гарын үсэг зурж баталгаажуулна.

15.Мэдүүлэг өгч байгаа хүнд мэдэгдэж, дуу, дуу-дүрсний бичлэг хийж болно.

4.11 дүгээр зүйл.Насанд хүрээгүй хүнээс мэдүүлэг авах

1.Арван найман насанд хүрээгүй хүнээс мэдүүлэг авахдаа түүний хууль ёсны төлөөлөгч, эсхүл өмгөөлөгч, шаардлагатай тохиолдолд сурган хүмүүжүүлэгч, эсхүл сэтгэл зүйч, эсхүл нийгмийн ажилтныг байлцуулна.

2.Эрх бүхий албан тушаалтны зөвшөөрснөөр хууль ёсны төлөөлөгч, сэтгэл зүйч, сурган хүмүүжүүлэгч, нийгмийн ажилтан арван найман насанд хүрээгүй хүнээс асуултыг зөв ойлгосон, хариултаа зөв илэрхийлсэн эсэхийг тодруулан асууж, тайлбарлаж болно.

3.Арван найман насанд хүрээгүй хүнээс мэдүүлэг авахдаа энэ хуулийн 4.10 дугаар зүйлд заасан журмыг баримтална.

4.12 дугаар зүйл.Шинжилгээнд зориулж хэв загвар, дээж авах

1.Шинжилгээ хийх зорилгоор хүн, эд зүйл, баримт бичиг, түүхий эд, бараа, ургамал, мал амьтнаас хэв загвар, дээж авч болно.

2.Энэ хуулийн 1.8 дугаар зүйлийн 5.7-д заасан эрх бүхий албан тушаалтан хүний биенээс биологийн дээж авч болно.

3.Шинжилгээнд зориулж хэв загвар, дээж авах ажиллагаанд мэргэжилтнийг оролцуулж болно.

4.Орчин тойрондоо аюул учруулж болзошгүй мал, амьтан, тэсэрч дэлбэрэх, хорт бодис, бусад байдлаар аюул учруулж болзошгүй эд зүйлээс хэв загвар, дээж авахдаа бусдын аюулгүй байдлыг хангах арга хэмжээг урьдчилан авна.

5.Шинжилгээнд зориулан хэв загвар, дээж авах, бүрэн бүтэн байдал, ариун чанар, хадгалалт, тээвэрлэлт, температурын горимыг Засгийн газар батална.

6.Шинжилгээнд зориулж хэв загвар, дээж авах ажиллагаанд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 26.9, 26.10 дугаар зүйлд заасан журмыг баримтална.

4.13 дугаар зүйл.Шинжилгээ хийлгэх

1.Эрх бүхий албан тушаалтан шийдвэр гаргаж эд зүйл, баримт бичиг, түүхий эд, бараа, ургамал, мал амьтанд шинжилгээ хийлгэнэ.

2.Дараахь тохиолдолд хүнд холбогдуулан прокурорын зөвшөөрлөөр шинжилгээ хийлгэж болно:

2.1.гэрч, хохирогч, холбогдогч зөрчил шалган шийдвэрлэхэд ач холбогдол бүхий байдлыг бодитой тусгаж, зөв мэдүүлэг өгөх чадвартай эсэхэд эргэлзээ төрвөл сэтгэцийн байдлыг тодорхойлох;

2.2.холбогдогчийг донтох сэтгэцийн эмгэгтэй эсэхийг тогтоох шаардлагатай бол;

2.3.холбогдогчийн насыг гэрчлэх баримт бичиг байхгүй бөгөөд түүний насыг тогтоох нь зөрчил шалган шийдвэрлэхэд ач холбогдолтой бол.

3.Зөрчил шалган шийдвэрлэхэд эд зүйл, хөрөнгөд үнэлгээ тогтоох,тусгай мэдлэг шаардагдах асуудлыг тодруулах зорилгоор эрх бүхий албан тушаалтан, прокурор, шүүхээс шинжээчийг томилно.

4.Тусгай мэдлэг, мэргэжил эзэмшсэн эрх бүхий албан тушаалтан өөрөө бие дааж шинжилгээ хийх, эсхүл эрх бүхий албан тушаалтан мэргэжлийн лабораторийг ашиглан шинжилгээ хийлгэж болно.

5.Шинжээч шинжилгээ хийж дүгнэлт гаргахдаа Шүүхийн шинжилгээний тухай хуульд² заасан журмыг баримтална.

6.Оролцогч энэ зүйлийн 5 дахь хэсэгт заасан шинжээчийн дүгнэлттэй санал нийлэхгүй бол эрх бүхий албан тушаалтан, прокурорт энэ хуульд заасан журмын дагуу гомдол гаргаж болно.

7.Оролцогчийн хүсэлтээр дахин шинжилгээг нэг удаа хийж болно.

4.14 дүгээр зүйл.Хураан авсан хөрөнгө, орлого, эд зүйлийн талаар авах арга хэмжээ

1.Хураан авсан хөрөнгө, орлого, эд зүйл, зэвсэг, хэрэгсэл, тээврийн хэрэгсэл, уналга, зөрчил шалгах ажиллагаанд ач холбогдолтой эд зүйл, баримт бичгийн талаар авах арга хэмжээтэй холбоотой үүсэх харилцааг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 20.1, 20.2, 20.3, 20.4, 20.5 дугаар зүйлд заасан журмаар зохицуулна.

4.15 дугаар зүйл.Тэмдэглэл үйлдэх журам

1.Энэ хуульд өөрөөр заагаагүй бол тэмдэглэлд зөрчил шалган шийдвэрлэх тодорхой ажиллагааны явц, дэс дараалал, илэрсэн нөхцөл байдал, авсан арга хэмжээ, үр дүн болон дараахь нийтлэг зүйлийг тусгана:

1.1.ажиллагааг явуулсан эрх бүхий албан тушаалтны нэр, албан тушаал;

1.2.ажиллагааг явуулсан газар, эхэлсэн, дууссан он, сар, өдөр, цаг, минут, хэрэгжүүлэх явцад хугацаа тасалдсан бол түүний шалтгаан, хугацаа;

1.3.ажиллагааг прокурорын зөвшөөрлөөр явуулж байгаа бол зөвшөөрлийн дугаар, хүчинтэй хугацаа;

1.4.ажиллагааг хойшлуулшгүй тохиолдолд явуулж байгаа бол үндэслэл бүхий нөхцөл байдлын талаар;

1.5.зөрчил шалгах ажиллагаанд оролцсон хүний эцэг /эх/-ийн болон өөрийн нэр, оршин суугаа газрын хаяг, байршил;

2 Шүүхийн шинжилгээний тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2010 оны 2 дугаарт нийтлэгдсэн.

1.6.ажиллагаанд байлцсан бусад хүний хувийн баримт бичиг дэх мэдээлэл;

1.7.ажиллагаанд оролцсон хүнд эрх, үүргийг тайлбарласан тухай;

1.8.оролцогч, гэрчээс санал, хүсэлт гаргасан эсэх, түүнийг хэрхэн шийдвэрлэсэн.

2.Тэмдэглэлд эрх бүхий албан тушаалтан, ажиллагаанд оролцсон хүн гарын үсэг зурна. Тэмдэглэл хэд хэдэн хуудастай бол ажиллагаанд оролцсон хүн хуудасны нүүр тус бүрд гарын үсэг зурна.

3.Тэмдэглэлд нэмэлт оруулсан, засвар хийсэн бол ямар засвар, өөрчлөлт хийсэн талаар тусгаж, энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан аргаар баталгаажуулна. Гарын үсэг зурахаас татгалзсан, эсхүл баталгаажуулах боломжгүй бол шалтгааныг тэмдэглэлд тусгана.

4.Ажиллагааны явцад хийсэн дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэг, гэрэл зураг, гар зураглал, хэв загварыг тэмдэглэлд хавсаргана.

5.Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны явцыг дуу-дүрсний бичлэгээр бэхжүүлж болно.

6.Хялбаршуулсан журмаар зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны тэмдэглэл нь энэ зүйлд заасан шаардлагыг бүрэн хангасан байхыг шаардахгүй.

ТАВДУГААР БҮЛЭГ ЭРХ ХЯЗГААРЛАХ АРГА ХЭМЖЭЭ

5.1 дүгээр зүйл.Эрх хязгаарлах арга хэмжээ

1.Эрх бүхий албан тушаалтан зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны хэвийн нөхцөлийг хангах зорилгоор дараахь эрх хязгаарлах арга хэмжээг давхардуулан хэрэглэж болно:

- 1.1.хүнийг түр саатуулах;
- 1.2.үйл ажиллагаа, ашиглалтыг түр зогсоох;
- 1.3.тээврийн хэрэгслийг түр саатуулах;
- 1.4.холбогдогчийн баримт бичгийг хураан авах;
- 1.5.зорчих эрхийг хязгаарлах.

2.Эрх бүхий албан тушаалтан, зөрчлийн хэрэг бүртгэлтийг удирдах албан тушаалтан, прокурор дараахь тохиолдолд эрх хязгаарлах арга хэмжээг цуцална:

- 2.1.зөрчлийн хэрэг бүртгэлт дууссан;
- 2.2.албадлагын арга хэмжээ авсан үндэслэл арилсан;
- 2.3.албадлагын арга хэмжээг үндэслэлгүй авсан нь тогтоогдсон.

3.Эрх хязгаарлах арга хэмжээг хэрэгжүүлэх нөхцөл, журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, Улсын ерөнхий прокурор хамтран батална.

5.2 дугаар зүйл.Түр саатуулах

1.Дор дурдсан эрх бүхий албан тушаалтан дараахь хугацаагаар хүнийг саатуулна:

1.1.холбогдогчийг хэн болохыг тогтоох зорилгоор 6 цаг хүртэл хугацаагаар тагнуулын болон цагдаагийн байгууллагын эрх бүхий ажилтан, хилийн төлөөлөгч, түүний орлогч, туслах, гадаадын иргэний хяналтын улсын байцаагч;

1.2.холбогдогч согтуурсан, мансуурсан байдалтай үедээ зөрчил үйлдсэн бол 24 цаг хүртэл хугацаагаар цагдаагийн байгууллагын эрх бүхий ажилтан;

1.3.хилийн дэглэм зөрсөн хүнийн хувийн байдлыг тогтоох зорилгоор 7 хоног хүртэл хугацаагаар хилийн төлөөлөгч, түүний орлогч, туслах;

1.4.зөрчил үйлдсэн гадаадын иргэний хувийн байдлыг тогтоох, эсхүл зөрчил шалган шийдвэрлэх явцад саад учруулж болзошгүй, зөрчил дахин үйлдэж болзошгүй бол шүүхийн шийдвэрээр 30 хүртэл хоног саатуулж болно.

2.Гадаадын иргэний хяналтын улсын байцаагч энэ зүйлийн 1.4-т заасан үндэслэлээр саатуулсан гадаадын иргэний талаар гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад 24 цагийн дотор мэдэгдэнэ.

3.Саатуулагдсан гадаадын иргэнийг гадаадын иргэнийг саатуулах байранд саатуулах бөгөөд зардлыг өөрөөр нь, эсхүл Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн³ 10.1.2 дахь заалтад заасны дагуу баталгаа гаргасан иргэн, аж ахуй нэгж, байгууллагаар төлүүлнэ.

4.Энэ зүйлийн 1.3, 1.4-т зааснаар хүнийг саатуулсан даруй прокурорт мэдэгдэнэ.

5.Гадаадын иргэнийг Монгол Улсаас албадан гаргахад Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 37, 38 дугаар зүйлд заасан журмыг мөрдөнө.

5.3 дугаар зүйл.Үйл ажиллагаа, ашиглалтыг түр зогсоох

1.Эрх бүхий албан тушаалтны саналыг үндэслэлтэй гэж үзвэл прокурор зөрчлийн улмаас хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд шууд, эсхүл шууд бусаар хор хохирол учруулж байгаа, эсхүл учруулж болох нөхцөл байдал үүссэн үед холбогдогчийн ажил, үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагааг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн, эсхүл барилга байгууламж, машин, тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн ашиглалт, үйл ажиллагааг түр зогсоох тухай шийдвэр гаргана.

2.Эрх бүхий албан тушаалтан нь хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд шууд хохирол учирч болзошгүй гэж үзвэл энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан эрх хязгаарлах арга хэмжээг авч, энэ тухай прокурорт даруй мэдэгдэнэ.

3 Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2010 оны 32 дугаарт нийтлэгдсэн.

3.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан шийдвэрийн хэрэгжилтийг эрх бүхий албан тушаалтан хангуулах арга хэмжээ авна.

4.Прокурор нь энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу эрх бүхий албан тушаалтны авсан эрх хязгаарлах арга хэмжээг хүчинтэйд тооцох эсэх асуудлыг даруй шийдвэрлэнэ.

5.4 дүгээр зүйл.Тээврийн хэрэгслийг түр саатуулах

1.Зөрчил шалгах ажиллагаатай холбогдуулан тээврийн хэрэгслийг түр саатуулах, шилжүүлэн байрлуулах бол Хууль сахиулах ажиллагааны тухай хуулийн 2.7, 2.8 дугаар зүйлд заасан журмыг баримтална.

5.5 дугаар зүйл.Баримт бичгийг хураан авах

1.Эрх бүхий албан тушаалтан холбогдогчийн жолоодох эрхийн үнэмлэх, мэргэжлийн үнэмлэх, үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл зэрэг баримт бичгийг хураан авч гаргасан шийдвэрийг холбогдогчид өгнө.

2.Холбогдогч хураалгасан баримт бичгийг бүрэн эхээр нь ашиглах зайлшгүй шаардлагатай бол эрх бүхий албан тушаалтанд хүсэлт гаргаж шийдвэрлүүлнэ.

5.6 дугаар зүйл.Зорчих эрхийг хязгаарлах

1.Прокурор нь Зөрчлийн тухай хуульд арван мянгаас дээш нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох шийтгэл оногдуулах зөрчилд холбогдогчийг зөрчил шалгах ажиллагаанд саад учруулж болзошгүй талаархи эрх бүхий албан тушаалтны саналыг үндэслэлтэй гэж үзвэл тодорхой газарт очих, Монгол Улсын хилээр гарах эрхийг хязгаарлаж болно.

2.Холбогдогчийн зорчих эрхийг хязгаарлах арга хэмжээ нь зөрчил шалган шийдвэрлэх нийт хугацаанаас хэтэрч болохгүй.

3.Холбогдогчид авсан зорчих эрхийг хязгаарласан тухай прокурорын шийдвэрийг холбогдох байгууллага, албан тушаалтан хэрэгжүүлнэ.

4.Прокурор энэ хуулийн 5.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан үндэслэлээр зорчих эрхийг хязгаарлах арга хэмжээг хүчингүй болгоно.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ ЗӨРЧЛИЙН ХЭРЭГ БҮРТГЭЛТ

6.1 дүгээр зүйл.Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулах үндэслэл

1.Дараахь тохиолдолд эрх бүхий албан тушаалтан зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулна:

1.1.үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэх явцад энэ хуулиар шалган шийдвэрлэхээр харьяалуулсан зөрчлийн шинжтэй үйлдэл, эс үйлдэхүйг илрүүлсэн;

1.2.хүн, хуулийн этгээдээс зөрчлийн талаархи гомдол гаргасан, эсхүл мэдээлсэн;

1.3.зөрчил үйлдсэн хүн өөрийгөө илчилж ирсэн;

1.4.байгууллага, албан тушаалтнаас харьяаллын дагуу холбогдох баримтыг шилжүүлэн ирүүлсэн.

2.Эрх бүхий албан тушаалтан энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчлийн шинжтэй үйлдэл, эс үйлдэхүйг илрүүлсэн, эсхүл гомдол, мэдээллийг хүлээн авсан даруй дараахь шийдвэрийн аль нэгийг гаргана:

2.1.гомдол, мэдээллийг харьяаллын дагуу шилжүүлэх;

2.2. гомдол, мэдээллийг хүлээн авахаас татгалзах;

2.3. хялбаршуулсан журмаар зөрчил шалган шийдвэрлэх.

2.4.зөрчлийн хэрэг бүртгэлтийн хэрэг нээх;

6.2 дугаар зүйл.Зөрчлийн талаархи гомдол,мэдээлэл хүлээн авах журам

1.Эрх бүхий байгууллага нь хүн, хуулийн этгээд, албан тушаалтнаас гаргасан зөрчлийн талаархи гомдол, мэдээллийг амаар, бичгээр болон харилцаа холбооны хэрэгслээр дамжуулан хүлээн авна.

2.Бичгээр гаргасан гомдолд гомдол гаргагч нь эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, оршин суугаа газрын хаяг, эсхүл шуудангийн хаяг, утасны дугаараа бичиж, гарын үсэг зурсан байна.

3.Амаар шууд, эсхүл утас, факс, цахим шуудангаар ирүүлсэн гомдлыг тэмдэглэл үйлдэн хүлээн авна. Тэмдэглэлд энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан мэдээллийг тусгаж, хүлээн авсан эрх бүхий албан тушаалтан гарын үсэг зурна.

4.Байгууллага, албан тушаалтан, хуулийн этгээд гомдлыг бичгээр гаргах бөгөөд түүнд холбогдох баримт, материалыг хавсаргаж болно.

5.Эрх бүхий байгууллага, албан тушаалтан зөрчлийн талаархи гомдлыг хүлээн авахдаа дараахь арга хэмжээг хэрэгжүүлнэ:

5.1.гомдол гаргагчид эдлэх эрх, үүргийг танилцуулж, санаатай худал мэдээлвэл хуулийн дагуу хариуцлага хүлээх талаар сануулах;

5.2.гомдлыг амаар гаргаж байгаа бол зөрчлийн талаар тэмдэглэлд тусган гомдол гаргагч саналаа оруулж, гарын үсэг зурах боломжоор хангах;

5.3.харилцаа холбооны хэрэгслээр дамжуулан гомдлыг хүлээн авсан бол бэхжүүлэх;

5.4.хүлээн авсан гомдолд тухайн гомдол гаргагч гарын үсэг зурсан эсэхийг нягталж, хүлээн авсан он, сар, өдөр, цаг, минутыг тэмдэглэн бүртгэх.

6.Эрх бүхий байгууллага, албан тушаалтан гомдол гаргагч, мэдээлэл өгсөн хүн, мэдээллийн нууцыг хадгалж, шаардлагатай бол мэдээлэгчийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээ авна.

7.Зөрчлийн талаархи мэдээллийг төлбөртэй авч болно. Мэдээллийг төлбөртэй авах журмыг сангийн болон хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

6.3 дугаар зүйл. Зөрчлөө илчлэн мэдээлэх

1.Зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээд үйлдсэн зөрчлөө сайн дураараа илчилсэн мэдээллийг бичгээр болон амаар гаргаж болно.

2.Зөрчил үйлдсэн хүн өөрийгөө илчилж ирсэн тохиолдолд эрх бүхий албан тушаалтан түүнд өөрийнхөө болон гэр бүлийн гишүүд, эцэг эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх, өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах эрхтэй болохыг нь танилцуулна.

6.4 дүгээр зүйл.Зөрчлийн талаархи гомдол, мэдээллийг харьяаллын дагуу шилжүүлэх

1.Зөрчлийн хэрэг бүртгэлтийг удирдах албан тушаалтан зөрчлийн талаархи гомдол, мэдээлэл, зөрчлийн хэрэг бүртгэлтийн хэрэг тухайн байгууллагын харьяаллын биш болох нь тогтоогдвол прокурорт танилцуулж, харьяаллыг шийдвэрлүүлнэ.

2.Эрх бүхий албан тушаалтан зөрчлийг хянан шалгах явцад гэмт хэргийн шинжтэй болохыг тогтоовол холбогдох баримтыг харьяаллын дагуу шалгуулахаар прокурорт даруй шилжүүлнэ.

3.Эрх бүхий албан тушаалтан энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу гомдол, мэдээллийг шилжүүлэх тохиолдолд зөрчлийг таслан зогсоох, зөрчлийн ул мөрийг хамгаалах, бэхжүүлэх арга хэмжээ авна.

4.Илэрсэн зөрчил нь зөрчлийн хэрэг бүртгэх хэд хэдэн байгууллагад харьяалагдахаар бол өөрийн харьяалах зөрчлийг шалган шийдвэрлэж, зөрчлийн талаархи бусад мэдээллийг харьяаллын дагуу шалгуулахаар шилжүүлнэ.

6.5 дугаар зүйл.Зөрчлийн талаархи гомдол, мэдээллийг хүлээн авахаас татгалзах

1.Хүн, хуулийн этгээд, албан тушаалтнаас ирүүлсэн гомдол, мэдээлэлд энэ хуулийн 1.9 дүгээр зүйлд заасан нөхцөл байдал тогтоогдвол хүлээн авахаас татгалзаж, шийдвэр гаргана.

2.Зөрчлийн талаархи гомдол, мэдээлэл гаргасан хүн, хуулийн этгээд, албан тушаалтан нь энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан шийдвэрийг хүлээн зөвшөөрөхгүй бол энэ хуулийн 1.12 дугаар зүйлд заасны дагуу гомдол гаргана.

6.6 дугаар зүйл.Хялбаршуулсан журмаар зөрчил шалган шийдвэрлэх

1.Дараахь үндэслэлийн аль нэг нь тогтоогдвол эрх бүхий албан тушаалтан хялбаршуулсан журмаар зөрчлийг шалган шийдвэрлэнэ:

1.1.зөрчил үйлдэгдсэн нь ил тодорхой, зөрчил, учирсан хохирлыг нотлох талаар зөрчлийн хэрэг бүртгэлт явуулах шаардлагагүй бол;

1.2.зөрчил үйлдэгдсэн, учруулсан хохирол нь нотлох баримтаар тогтоогдож холбогдогч зөрчил үйлдсэнээ сайн дураараа хүлээн зөвшөөрсөн бол.

2.Холбогдогч энэ зүйлийн 1.2-т заасан үндэслэлээр зөрчил шалгах ажиллагааг хялбаршуулсан журмаар явуулах тухай хүсэлтийг эрх бүхий албан тушаалтанд зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны аль ч үед гаргаж болно.

3.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан үндэслэлээр эрх бүхий албан тушаалтан газар дээр нь торгох шийтгэл оногдуулна.

4.Зөрчлийн хэрэг бүртгэлтийн явцад холбогдогч зөрчил үйлдсэнээ сайн дураараа хүлээн зөвшөөрсөн, эсхүл зөрчил үйлдсэн нь тогтоогдож байгаа бол эрх бүхий албан тушаалтан шийтгэл оногдуулна.

5.Холбогдогчийг зөрчил үйлдсэн болохыг хүлээн зөвшөөрүүлэхээр тулган шаардах, албадахыг хориглоно.

6.Хялбаршуулсан журмаар зөрчил шалган шийдвэрлэсэн даруй прокурорын нэгдсэн бүртгэлд бүртгүүлнэ.

6.7 дугаар зүйл.Зөрчлийн хэрэг нээх

1.Эрх бүхий албан тушаалтан энэ хуулийн 6.6 дугаар зүйлийн 1.1-д заасан тохиолдолд зөрчлийн хэрэг хэрэг нээж, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулна.

2.Эрх бүхий байгууллага, албан тушаалтан энэ зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар зөрчлийн хэрэг хэрэг нээсэн даруй прокурорын нэгдсэн бүртгэлд бүртгүүлж, танилцуулна.

6.8 дугаар зүйл.Зөрчлийн хэрэг бүртгэлтийн хугацаа

1.Эрх бүхий албан тушаалтан 15 хүртэл хоногийн дотор зөрчлийн хэрэг бүртгэлтийн ажиллагаа явуулна. Зөрчил шалгах нэмэлт ажиллагаа явуулж нотлох баримт цуглуулах шаардлагатай бол тухайн зөрчлийн хэрэг бүртгэлтийг удирдах албан тушаалтны шийдвэрээр хугацааг 15 хүртэл хоногоор нэг удаа сунгаж болно.

2.Зөрчлийн хэрэг бүртгэлтийн хэргийг харьяаллын дагуу шилжүүлсэн тохиолдолд хэрэг бүртгэлтийн хугацааг үргэлжлүүлэн тоолно.

6.9 дүгээр зүйл.Зөрчлийн хэрэг бүртгэлтийн материалтай танилцуулах

1.Эрх бүхий албан тушаалтаннь зөрчлийн хэрэг бүртгэлтийг дуусгахаас өмнө холбогдогч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчид зөрчлийн хэрэг бүртгэлтийн материалтай танилцах эрхээ эдлэх боломжоор хангана.

2.Холбогдогч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч зөрчлийн хэрэг бүртгэлтийн материалтай танилцсаны дараа нэмэлт ажиллагаа хийлгэх саналаа бичгээр гаргаж болно.

3.Эрх бүхий албан тушаалтан нь энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан саналыг үндэслэлтэй гэж үзвэл зөрчил шалгах нэмэлт ажиллагаа явуулна.

4.Энэ зүйлд заасан журам нь энэ хуулийн 6.6 дугаар зүйлд хамаарахгүй.

6.10 дугаар зүйл.Зөрчлийн хэрэг бүртгэлтийг дуусгах

1.Эрх бүхий албан тушаалтан зөрчлийн хэрэг бүртгэлтийг дуусгаж дараахь шийдвэр гаргана:

- 1.1.зөрчлийн хэргийг хэрэгсэхгүй болгох;
- 1.2.шийтгэл оногдуулах.
- 1.3.шийтгэл оногдуулж, албадлагын арга хэмжээ авахуулах хүсэлтийг шүүхэд гаргах.

6.11 дүгээр зүйл.Зөрчлийн хэргийг хэрэгсэхгүй болгох

1.Дараахь үндэслэл тогтоогдвол прокурор, эрх бүхий албан тушаалтан зөрчлийн хэргийг хэрэгсэхгүй болгох шийдвэр гаргана:

- 1.1.энэ хуулийн 1.9 дүгээр зүйлд заасан;
- 1.2.Зөрчлийн тухай хуулийн 2.3 дугаар зүйлд заасан;
- 1.3.зөрчил үйлдэх үедээ шийтгэл хүлээх насанд хүрээгүй.

2.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан шийдвэрийг гомдол, мэдээлэл гаргагч, холбогдогчид 7 хоногийн дотор мэдэгдэж болно.

3.Энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан шийдвэрийг хүлээн авсан оролцогч зөрчлийн хэргийг үндэслэлгүй хэрэгсэхгүй болгосон гэж үзвэл энэ хуулийн 1.12 дугаар зүйлд заасны дагуу гомдол гаргана.

4.Зөрчлийн хэргийг хэрэгсэхгүй болгосон шийдвэрийг үндэслэлгүй гэж үзвэл дээд шатны удирдах албан тушаалтан, прокурор шийдвэрийг хүчингүй болгоно.

6.12 дугаар зүйл.Шийтгэл оногдуулах

1.Эрх бүхий албан тушаалтан шийтгэл оногдуулахдаа дараахь нөхцөлийг тогтоосон байна:

- 1.1.зөрчлийн хэргийг хэрэгсэхгүй болгох үндэслэл байгаа эсэх;
- 1.2.зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг хуульд заасан үндэслэл, журмын дагуу явуулсан эсэх;

1.3.хүн, хуулийн этгээдийн зөрчил үйлдсэнийг нотлох баримт бүрдсэн эсэх;

1.4.Зөрчлийн тухай хуульд заасан албадлагын арга хэмжээ хэрэглэх үндэслэл байгаа эсэх.

2.Зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд шийтгэл оногдуулах шийдвэр нь шийтгэлийн хуудас хэлбэртэй байна.

3.Эрх бүхий албан тушаалтан нь шийтгэл оногдуулах тухай шийдвэртээ шийтгэл, албадлагын арга хэмжээний төрөл, хэмжээ, түүнийг сайн дураараа биелүүлэх хугацаа, хэлбэр, нөхцөлийг заана.

4.Шийтгэлийн хуудасны хувийг зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд хүргүүлнэ.

5.Шийтгэлийн хуудасны загварыг Засгийн газар батална.

6.13 дугаар зүйл.Албадлагын арга хэмжээ хэрэглэх

1.Эрх бүхий албан тушаатан нь зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд Зөрчлийн тухай хуульд заасан албадлагын арга хэмжээ хэрэглэх үндэслэл байгаа эсэхийг шалган тогтооно.

2.Эрх бүхий албан тушаалтан нь зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд хуульд заасны дагуу албадлагын арга хэмжээг хэрэглэх үндэслэлтэй гэж үзвэл Зөрчлийн тухай хуулийн 4.2 дугаар зүйлийн 4.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 4.3 дугаар зүйлд заасан албадлагын арга хэмжээг хэрэглэнэ.

3.Эрх бүхий албан тушаалтан нь зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд зөрчлийн тухай хуулийн 4.1 дүгээр зүйл, 4.2 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 4.4 дүгээр зүйлд заасан албадлагын арга хэмжээ хэрэглэх үндэслэлтэй гэж үзвэл албадлагын арга хэмжээ авахуулах тухай хүсэлтийг шийтгэл оногдуулсан шийдвэр гаргаснаас хойш 24 цагийн дотор шүүхэд гаргана.

4.Эрх бүхий албан тушаалтан энэ зүйлийн 3 дахь хэсэгт заасан хүсэлтийг шүүх шийдвэрлэх хүртэл зөрчил үйлдэж олсон хөрөнгө, орлого, зөрчил үйлдэхэд ашигласан тээврийн хэрэгсэл, уналгыг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу хураан авах, эсхүл битүүмжилнэ.

5.Шийтгэл оногдуулсан шийдвэрт холбогдогчийн гаргасан гомдлыг шийдвэрлэх хүртэл түүнд албадлагын арга хэмжээ хэрэглэх тухай эрх бүхий албан тушаалтны хүсэлтийг шийдвэрлэхийг шүүх түдгэлзүүлнэ.

6.Шүүх энэ зүйлийн 3 дахь хэсэгт хүсэлтийг энэ хуулийн 8.1 дүгээр зүйлд заасан журмын дагуу шийдвэрлэнэ.

6.14 дүгээр зүйл.Зөрчлийн үр дагаврыг арилгах арга хэмжээ авах

1.Эрх бүхий албан тушаалтан нь зөрчлийн үр дагаврыг арилгах зорилгоор ариутгах, хоргүйжүүлэх, цэвэршүүлэх, засвар үйлчилгээ хийх, холбогдох бүтээгдэхүүнийг борлуулахыг хориглох, иргэний гүйлгээнээс буцаан татах, энэ талаар олон нийтэд зарлан мэдээлэх зэрэг арга хэмжээ авч болно.

2.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан арга хэмжээ авахыг зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд, зөрчил үйлдсэн хүн арван найман насанд хүрээгүй бол түүний хууль ёсны төлөөлөгчид хугацаа тогтоон даалгаж болно.

3.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан арга хэмжээний зардлыг зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээд хариуцна.

4.Зөрчлийн үр дагаврыг арилгах тухай эрх бүхий албан тушаалтны даалгаврыг зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээд биелүүлээгүй, эсхүл энэ арга хэмжээний зардлыг тогтоосон хугацаанд төлөөгүй бол энэ хуулийн 8.1 дүгээр зүйлд заасан журмын дагуу шүүхэд даруй хүсэлт гаргаж, шүүхийн шийдвэр гүйцэтгэх журмаар албадан гүйцэтгүүлнэ.

5.Албадан гүйцэтгүүлэхтэй холбоотой гарсан зардлыг холбогдох хүн, хуулийн этгээдээр нөхөн төлүүлнэ.

6.15 дугаар зүйл.Шийтгэл оногдуулсан шийдвэрийг биелүүлэх

1.Эрх бүхий албан тушаалтны шийдвэрийг зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээд хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор сайн дураар биелүүлнэ.

2.Зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээд нь торгох шийтгэлд заасан торгуулийг бэлэн, эсхүл бэлэн бус хэлбэрээр төлнө.

3.Эрх бүхий албан тушаалтан нь эрх хасах шийтгэл оногдуулсан талаар зохих байгууллагад мэдэгдэж, шийдвэрийн хувийг даруй хүргүүлнэ.

4.Зөрчил үйлдсний улмаас Монгол Улсад оршин суух эрх хасах шийтгэл хүлээсэн гадаадын иргэн, харьяалалгүй хүнийг Монгол Улсаас албадан гаргахад Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 37, 38 дугаар зүйлд журмыг мөрдөнө.

5.Монгол Улсад оршин суух эрх хасах шийтгэл хүлээсэн гадаадын иргэн, харьяалалгүй хүнийг Монгол Улсаас албадан гаргах хүртэл саатуулж болно.

6.Зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээд тогтоосон хугацаанд шийдвэрийг биелүүлээгүй бол шүүхийн шийдвэр гүйцэтгэх журмаар албадан гүйцэтгүүлэхээр эрх бүхий албан тушаалтан дараахь хүсэлтийг шүүхэд даруй гаргана:

6.1.шийтгэл оногдуулсан шийдвэрийг албадан биелүүлэх;

6.2.нийтэд тустай ажил хийлгэх албадлагын арга хэмжээ авахуулах.

7.Шийтгэлийн хуудсыг зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээд хүлээн аваагүй нь шийтгэл, албадлагын арга хэмжээг албадан хэрэгжүүлэхээс чөлөөлөх үндэслэл болохгүй.

8.Шийтгэл оногдуулсан шийдвэрийг албадан гүйцэтгэхтэй холбоотой гарсан зардлыг холбогдох хүн, хуулийн этгээдээр нөхөн төлүүлнэ.

6.16 дугаар зүйл.Зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хэрэгслийг хураах

1.Эрх бүхий албан тушаалтан зөрчил ашигласан зэвсэг, хэрэгслийг хураах албадлагын арга хэмжээг хэрэглэхдээ зэвсэг, хэрэгслийг сайн дураар гаргаж өгөх, зааж өгөх боломжийг тухайн этгээдэд олгоно.

2.Хураан авсан зэвсэг, хэрэгслийн жагсаалт, тэмдэглэлийг хураалгасан, эсхүл эзэмшигч, эсхүл түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчид даруй гардуулна.

3.Хураан авах ажиллагаанд Эрүүгийн хэрэг шалган шийдвэрлэх тухай хуулийн 22.1 дүгээр зүйлд заасан журмыг баримтална.

4.Тэсэрч дэлбэрэх, хордуулах бодисыг хураан авахдаа мэргэжлийн байгууллагад хандан гүйцэтгүүлж болно.

5.Хураан авсан эд зүйл, хэрэгслийг улсын орлого болгох, устгах журмыг Засгийн газар батална.

6.17 дугаар зүйл. Хохирол, нөхөн төлбөр гаргуулах

1.Эрх бүхий албан тушаалтан хохирол, нөхөн төлбөр тооцох, гаргуулах, хохирол барагдуулах, хор уршгийг арилгахад зарцуулах, улсын төсөвт төвлөрүүлэх журмыг Засгийн газар батална.

ДОЛДУГААР БҮЛЭГ ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНЫ ШИЙТГЭЛ ОНОГДУУЛСАН ШИЙДВЭРТ ГОМДОЛ ГАРГАХ

7.1 дүгээр зүйл.Эрх бүхий албан тушаалтны шийтгэл оногдуулсан шийдвэрт гомдол гаргах

1.Эрх бүхий албан тушаалтны шийтгэл оногдуулсан шийдвэрийг хүлээн зөвшөөрөөгүй оролцогч шийдвэрийг хүлээн авснаас хойш ажлын 5 өдрийн дотор прокурорт гомдол гаргаж болно.

2.Прокурор энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан гомдлыг хүлээн авснаас хойш ажлын 5 өдрийн дотор дараахь шийдвэрийг гаргана:

2.1.гомдлыг хэрэгсэхгүй болгож, эрх бүхий албан тушаалтны шийдвэрийг хэвээр үлдээх;

2.2.эрх бүхий албан тушаалтны шийдвэрийг хүчингүй болгож, шийдвэрийг өөрчлөх;

2.3.шийтгэл оногдуулсан эрх бүхий албан тушаалтны шийдвэрийг хүчингүй болгох.

3.Хуульд өөрөөр заагаагүй бол прокурор гомдлыг шийдвэрлэж дуусах хүртэлх хугацаанд шийдвэрийн биелэлт түдгэлзэнэ.

4.Оролцогч прокурорын шийдвэрийг хүлээн зөвшөөрөөгүй бол шийдвэрийг хүлээн авснаас хойш ажлын 5 өдрийн дотор энэ хуульд заасан харьяаллын дагуу шүүхэд гомдол гаргаж болно.

5.Энэ зүйлийн 2.2, 2.3-т заасан прокурорын шийдвэрт эрх бүхий албан тушаалтан ажлын 3 өдрийн дотор тухайн прокурорын газрын дээд шатны прокурорт нэг удаа гомдол гаргаж болно.

6.Прокурор нь энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан үндэслэлээр гомдлыг хянах явцад гэмт хэргийн шинж тогтоогдвол мөрдөн шалгуулахаар харьяалах байгууллагад шилжүүлнэ.

6.Эрх бүхий албан тушаалтны шийтгэл оногдуулсан шийдвэрт гомдол гаргах нь энэ хуулийн 1.12 дугаар зүйлд заасан журамд хамаарахгүй.

НАЙМДУГААР БҮЛЭГ ЗӨРЧИЛ ШҮҮХЭЭР ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГАА

8.1 дүгээр зүйл.Зөрчил шүүхээр хянан шийдвэрлэх ажиллагаа

1.Шүүх дараахь тохиолдолд зөрчлийг хянан шийдвэрлэнэ:

- 1.1.энэ хуулийн 6.12 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан хүсэлт;
- 1.2.энэ хуулийн 6.15 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт заасан хүсэлт;
- 1.3.энэ хуулийн 7.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасан гомдол.

2.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан үндэслэлээр хүсэлт, гомдол гаргасан бол зөрчлийн хэргийн материалыг 24 цагийн дотор эрх бүхий албан тушаалтан, прокурор нь шүүхэд хүргүүлнэ.

3.Энэ зүйлийн 1.1, 1.2-т заасан хүсэлтийг үндэслэн эрх бүхий албан тушаалтан, энэ зүйлийн 1.3-т заасан гомдлыг үндэслэн прокурор зөрчлийг хянан шийдвэрлэх шүүх хуралдаанд оролцоно.

4.Шүүх зөрчил хянан шийдвэрлэх ажиллагаа явуулахад энэ хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хуульд заасан нийтлэг журмыг удирдлага болгоно.

5.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан хүсэлт, гомдлыг шүүгч дангаар хянан шийдвэрлэнэ.

6.Шүүх энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан хүсэлт, гомдлыг хүлээн авснаас хойш ажлын 3 өдрийн дотор зөрчлийн хэргийг хянан шийдвэрлэнэ.

7.Зөрчлийн хэргийн ээдрээ, төвөгтэй байдлыг харгалзан зөрчлийн хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх хугацааг шүүгчийн саналыг харгалзан тухайн шүүхийн Ерөнхий шүүгч нэг удаа сунгаж болно.

8.Оролцогч шүүх хуралдаанд оролцох хүсэлт гаргаснаас бусад тохиолдолд шүүх хуралдаанд ирээгүй нь шүүх хуралдааныг хойшлуулах үндэслэл болохгүй.

9.Энэ зүйлийн 1.3-т заасан үндэслэлээр зөрчлийн хэргийг шүүхээр хянан шийдвэрлэх ажиллагаанд эрх бүхий албан тушаалтан нь гэрчийн эрх эдэлж, үүрэг хүлээж оролцоно.

10.Шүүгч шүүх хуралдааны дарааллыг прокурор, эсхүл эрх бүхий албан тушаалтан, оролцогчийн саналыг үндэслэн тогтооно.

11.Оролцогч нь гаргасан гомдол, түүний үндэслэлийн талаархи нотлох баримтыг шүүх хуралдаанд танилцуулна.

12.Шүүх хуралдаанд прокурор, эрх бүхий албан тушаалтан нь шийтгэл оногдуулсан шийдвэр, албадлагын арга хэмжээ хэрэглэх, шийдвэрийг албадан гүйцэтгүүлэх үндэслэл, оролцогч нь гаргасан гомдлын үндэслэлийг нэг удаа тайлбарлана.

13.Шүүх хуралдаанд прокурор, эрх бүхий албан тушаалтан, оролцогчийн хүсэлтийн дагуу шүүгч нь гэрчээс мэдүүлэг авч, бусад нотлох баримтыг шинжлэн судалж болно.

14.Шүүх хуралдаанд гэрчийн мэдүүлгийг сонссоны дараа шүүх шийдвэр гаргана.

15.Шүүх хуулийн 64.1-т заасан гомдол, хүсэлтийг үндэслэн зөрчлийн хэргийг хянан шийдвэрлэж дараахь шийдвэрийн аль нэгийг гаргана:

15.1.шийтгэлийг хэвээр үлдээх;

15.2.шийтгэлийг өөрчлөх;

15.3.шийтгэлээс чөлөөлөх;

15.4.шийтгэлийг хүчингүй болгох;

15.5.шийтгэлийг албадан гүйцэтгүүлэхээр эрх бүхий байгууллагад даалгаж, нийтэд тустай ажил цалин хөлсгүй хийлгэх албадлагын арга хэмжээ хэрэглэх;

15.6.албадлагын арга хэмжээ хэрэглэх, эсхүл татгалзах.

16.Шүүхээс гарах шийдвэр нь захирамж хэлбэртэй байна.

17.Шүүхийн шийдвэрийг эс зөвшөөрвөл эрх бүхий албан тушаалтан, оролцогч гомдол, прокурор эсэргүүцэл бичиж болно.

18.Зөрчлийн хэргийг хянан шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрт гомдол гаргах, эсэргүүцэл бичих, түүнийг хянан шийдвэрлэх ажиллагаанд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан үндэслэл, журмыг баримтална.

19.Зөрчлийн хэргийг хянан шийдвэрлэсэн давж заалдах шатны шүүхийн шийдвэр нь шүүхийн эцсийн шийдвэр байна.

ЕСДҮГЭЭР БҮЛЭГ ХУУЛЬ ХҮЧИН ТӨГӨЛДӨР БОЛОХ

9.1 дүгээр зүйл.Хууль хүчин төгөлдөр болох

1.Энэ хуулийг 2017 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг